

БАТЛАВ.
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН "ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН АЛБА ХААГЧДЫН АЛБАНЫ МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ" НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг: Зорилго

Зорилго: Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсүүдийн Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гал түймэр унтраах дүрэм, Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, Цэргийн нийтлэг дүрмийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, сахилга ёс зүй, цэрэгжилт жагсаалч байдлыг дээшлүүлэх, үйлчлэх хүрээний зам гарц, усан хангамжийн судалгаанд тодотгол хийх, гал унтраах шуурхай карт, шуурхай төлөвлөгөөг чанаржуулахад оршино.

Хоёр: Хамрах хүрээ, нэгдсэн арга хэмжээ явуулах хугацаа

Нэгдсэн арга хэмжээнд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн харьяа Гал түймэр унтраах, аврах ангиуд хамрагдана.

2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл 30 хоногийн хугацаанд зохион явуулна.

Гурав: Хүрэх үр дүн

1. Албан хаагчдын хууль эрх зүй, цэргийн хэргийн мэдлэг, албаны бэлэн байдал дээшлэн, сахилга ёс зүй, цэрэгжилт жагсаалч ажиллагаа сайжрах.

2. Гарсан гал түймрийг шуурхай унтраахад ашиглах гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, шуурхай картын боловсруулалт бодит, үр дүнд хүрсэн байна.

3. Албан хаагчдын мэргэжлийн ур чадвар сайжирч, гамшиг, аюулт үзэгдлийн үед ажиллах бэлэн байдал хангагдана.

Дөрөв: Зохион байгуулах ажлын чиглэл

Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн харьяа Гал түймэр унтраах, аврах ангиуд удирдамжийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын нэрэмжит "Ажил мэргэжлийн тэмцээн"-ийг зохион байгуулах.

2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/12 дугаар тушаалын дагуу албаны баримт бичгийг хөтөлж, ангийн цагийн хуваарийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж хэвших.
3. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Онцгой байдлын албаны дүрэм болон цэргийн нийтлэг дүрмээр танхимын сургалт зохион байгуулан үр дүнд хүрсэн байх.
4. Гал унтраах 3 шатны дасгал сургуулийг боловсруулсан төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулах.
5. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах.
6. Ангийн бие бүрэлдэхүүнийг хамруулан нутаг дэвсгэрийн үйлчлэх хүрээний зам, гарц, мухар гудамж, гүний болон зөөврийн худаг, ил, далд усны цэгийн /гидрант/ судалгаанд тодотгол хийж, ангийн захирагчийн ажлын зургаанд тэмдэглэл үйлдэн материалжуулах.
7. Гал түймэр унтраах шуурхай карт, шуурхай төлөвлөгөөнд тодотгол хийж, баталгаажуулан, дуудлага хүлээн авагчийн өрөөнд байршуулж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж хэвшүүлэх.

Тав: Мэдээ, тайлан ирүүлэх

Нэгдсэн арга хэмжээний тайлан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион явуулсан ажлын тайланг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр цахим хэлбэрээр Гал түймэртэй тэмцэх газрын Гал унтраах хэлтсийн untraahhelt@yaho.com /мэйл хаягт, тайланг /гэрэл зургаар баримтжуулан/ цаасаар 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн дотор ирүүлсэн байна.
- Хэд, хэдэн гал түймэр унтраах, аврах ангитай Онцгой байдлын газар, хэлтсүүд анги тус бүрээр зохион байгуулсан ажлын тайланг ирүүлнэ.
- Тайланд сайшааж, урамшуулсан болон сахилга хариуцлага алдсан алба хаагчдын цол, овог нэр, албан тушаалыг тодорхой тусгаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хавсаргаж ирүүлнэ.

Зургаа: Дүгнэх

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн дүгнэж, ололт амжилт, зөрчил дутагдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР